

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234708

МОНГОЛ ХЭЛНИЙ ЗАРИМ МӨХСӨН ДАГАВРЫН ТУХАЙ

Ж.Ганбаатар
Ө.Ундармаа

Товч агуулга: Залгаврын тогтолцоонд гарсан өөрчлөлт, залгавар бүтээврийн үүсэл гарал ба мөхлийн талаар судалгаа хийх нь хэлний түүхийн хувьд чухал ач холбогдолтой юм. Хэлний хувьсал хөгжлийн явцад шинэ бүтээвэр үүсэхээс гадна, зарим бүтээвэр хэрэглээгүй болж мөхдөг. Энэхүү өгүүлэлд Л.Бауерын тодорхойлсон дагавар мөхөх шалтгааныг монгол хэлний жишээ баримтаар тодруулахад дагаврын утга бүдгэрэх; үг бүтэх хэв маяг болон үг бүтэх загвар нь хэрэглээнээс гарах; дагаврын хувилбарын хэрэглээ нэмэгдсэнээр нөгөө хувилбар нь мөхөх зэрэг үзэгдэл түгээмэл байна. Түүнчлэн үгийн гарлыг судлан тогтооход чөлөөт болоод чөлөөт бус язгуурыг түүхэн үүднээс задлан тайлбарлах нь чухал юм. Гэвч монгол хэл шинжлэлд язгуурын бүтцийг цааш нь задалж анхдагч язгуурыг тогтоосон судалгаа цөөн байна. Анхдагч язгуурыг тогтоох нь мөхсөн дагаврын судалгаатай нягт холбогддог. Учир нь орчин цагийн монгол хэлний ихэнх амьд язгуур анхдагч язгуур, мөхсөн дагаврын нийлцээс бүтэж байна. Язгуурын бүтцэд шингэсэн дагаврыг тооны нэр бүтээх дагаврын жишээгээр тайлбарлаж, цөөн үгийн бүтцэд тохиолддог, шинэ үг бүтээдэггүй, утга нь тодорхой мэдэгдэхээ больсон дагаврыг мөхсөн дагавар гэж үзэх саналаа тус өгүүлэлд дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Үгийн бүтэц, анхдагч язгуур, чөлөөт язгуур, чөлөөт бус язгуур, дагаврын хувилбар, авиалбарын харилцан нөлөөлөл

1. Удиртгал. Язгуурыг цуваа цагийн үүднээс *амьд*, *мөхсөн*; хам цагийн үүднээс *чөлөөт* (*free root*), *чөлөөт бус язгуур* (*bound root*) гэж ангилж байна. Ш.Лувсанвандан язгуурыг *анхдагч*, *үүсмэл* гэж хоёр ангилаад “*анхдагч язгуур* нь цаашид үл задрах цэвэр язгуур байдаг бол *үүсмэл язгуур* нь идэвхгүй анхдагч язгуур дээр мөн идэвхгүй болсон нэг буюу хэдэн дагавар залгаж бүтсэн байна. Жишээлбэл, *цагаан* гэсэн үгэнд тохиолдох *ца-* язгуур нь идэвхгүй анхдагч язгуур, *-га* нь идэвхгүй дагавар, энэ хоёр нийлж *цагаа-* гэсэн үүсмэл язгуур болно” (1963/2010: 76); “...Орчин цагийнхаа хэлэнд бодит утгаа алдаж, үг бүтээх, үндэс үүсгэхэд язгуур болж чадахгүй, ганцхан түүхийн үүднээс задлан үзвэл сая мэдэгдэх тийм язгуурыг *мөхсөн язгуур* гэнэ. ...Хэрэв ямар нэгэн үгийн язгуур мөхвөл түүний дагавар ч нэгэн адил мөхнө” (1964 /2019: 40-41) гэжээ. Тиймээс *ца-* анхдагч язгуураас үүссэн *цас*, *цан*, *цал* (*буурал*) зэргийг чөлөөт язгуур гэж үзэх бөгөөд түүний бүтэц дэх *-с*, *-н*, *-л* нь мөхсөн дагавар болно.

Монгол хэл шинжлэлийн бүтээлүүдэд мөхсөн язгуурын талаар Ш.Лувсанвандан (1964), Б.Ринчен (1966) нар дурдсан байдаг боловч мөхсөн дагаврын талаар тодорхой судалгаа байхгүй байна. Ер нь залгаврын тогтолцоонд (inflectional systems) гарсан өөрчлөлт, залгавар бүтээврийн үүсэл гарал ба мөхлийн талаар судлах нь хэлний түүхийн хувьд чухал ач холбогдолтой юм.

2. Дагавар мөхөх шалгаан. Зарим дагавар язгуурын бүтцэд шингэх, бусад дагавартай нийлж шинэ дагавар үүсгэх болон хэрэглээгүй болж мөхөх нь бий. Л.Бауер (L.Bauer) дагавар мөхөх шалтгааныг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тухайн дагаврыг залгах боломжтой үндэс дуусах (үг нь хэрэглэгдэх боловч залгавар тодорхойгүй) үед;
- Үндсийн бүтэц тодорхойгүй болох үед;
- Үндэс нь танигдахааргүй болсон үед;
- Дагаврын утгыг урьдчилан таамаглах боломжгүй болоход;
- Үг бүтэх загвар нь хангалттай жишээгээр дэмжигдээгүй үед үг бүтээх үйл явц нь мөхдөг;
- Үг бүтэх хэв маяг, загвар нь моодноос гарах үед үг бүтээх үйл явц нь мөхдөг;
- Авиалбарын хувьслаас болж хэлбэр нь өөрчлөгдөх үед;
- Дагаврын хувилбарын нэгнийх нь хэрэглээ идэвхжих үед нөгөө хувилбар нь мөхдөг (2023: 3-7) гэжээ.

Хэлний түүхэн хувьслын явцад язгуур, дагавар хоёр нэгдэж нэгэн бүтээвэр болох, авиалбарын харилцан нөлөөлөл (phonological phenomenon)-өөс болж язгуур, үндсийн бүтэц өөрчлөгдөх тохиолдол бий. Дагавар мөхөх дээрх шалтгаанууд нь монгол хэлэнд ч түгээмэл бөгөөд зарим шалтгааныг хэлний баримтаар тодруулъя.

2.1. Дагавар утгаа алдах нь. Бүтээврийн үндсэн шинжийн нэг нь утгат шинж боловч мөхсөн дагаврын тухайд түүний утгыг тодорхойлох боломжгүй юм. Нэр үг бүтээх *-чин* дагавар бүхий *малчин, барилгачин, зөгийчин, хөгжимчин* зэрэг үгээс уг дагаврыг “хүний эрхлэх ажил мэргэжлийн утга” илтгэдгийг хялбархан таньж болно. Гэтэл сургалт, судалгааны бүтээлүүдэд амьд бүтээвэр гэж үздэг зарим дагаврын утгыг тухайн дагавар бүхий үгсийн зэрэгцсэн харьцаанаас ч тодорхойлж, таамаглаж чадахгүй байх нь бий.

Хэлний хувьслын тодорхой нэг үед бүтээлч буюу олон үгийн бүтцэд тохиолдож байсан дагавар бүтээлч биш болж, улмаар утгаа алдан мөхөж болно. Тухайлбал, монгол хэлний *-мcAp* дагавар *ухамсар, санамсар, тоомсор, өлсөмсөр, хийсэмсэр* зэрэг үгийн бүтцэд давтагдана. Үүнээс *өлсөмсөр, хийсэмсэр* нь хуучран мартагджээ. Дээрх үгсээс *-мcAp* дагаврын утгыг тодорхойлоход хэцүү бөгөөд тухайн дагавар орчин цагийн монгол хэлэнд *ухамсар, санамсар, тоомсор* зэрэг ердөө гурван үгийн бүтцэд тохиолдоно. Судлаачид *-мcAp* дагаврын *-сAp (-sar)*-ыг түрэг хэлний *-siz* хэмээх үгүйсгэх утгатай дагавартай гарал нэгтэй гэж үзжээ (Lewicki, 1949: 259-267; Hashimoto, 1984: 421-426). *-мcAp* дагавар өөрийн утгаа алдсан учраас *санамсаргүй, тоомсоргүй, ухамсаргүй* гэх зэргээр ардаа дахин үгүйсгэх утгатай *-гүй* дагавартай хэрэглэгдэх болсон байна. Шинэ үг

бүтээдэггүй, *ухамсар*-аас бусад үгэнд дангаараа буюу *-гүй* дагавар авахгүйгээр хэрэглэгдэхээ больсон учраас *-мсАр* дагаврыг утгаа алдсан, мөхсөн дагавар гэж үзэж болно. Дагавар нь мөхсөн ч тухайн үг хэрэглэгдсээр байдаг.

2.2. Үг бүтэх хэв маяг болон үг бүтэх загвар хэрэглээнээс гарах нь. Орчин цагийн монгол хэлэнд шинэ үг бүтээх болон үг хувилгах ёсонд нийлэг аргаас илүү задлаг арга бүтээлч болжээ. Тиймээс зарим дагавар, нөхцөлийн хэрэглээ багасаж, задлаг хэлбэртээ түрэгдэх хандлагатай байна. Тодруулбал, тодотгон холбох *-АА* нөхцөл *яваа, суугаа, байгаа* зэрэг үгэнд одоо цагийн утгаа хадгалж бусад тохиолдолд “*V+-ж байгаа*” (*ирж байгаа, сууж байгаа* гэх мэт) хэлбэрт үүргээ алджээ. Мөн нөхцөлдүүлэн холбохын *-нгаа (явангаа)* нөхцөлөөр илрэх утга “*V+-х замдаа*” (*явах замдаа*) гэсэн задлаг хэлбэрээр илрэх нь түгээмэл болж байна. *-АА* бүтээвэр *яваа, суугаа, байгаа* зэрэг үгийн бүтцэд одоо цагийн утгаа хадгалж буй боловч бусад үндсэнд үл залгана (**очоо – очиж байгаа, *сураа – сурч байгаа* гэх мэт). Энэ бол бүтээвэр нь амьд боловч “үг хувилгах болон бүтээх үйл явц, хэв маяг” нь мөхөж буй үзэгдэл юм. Үг бүтэх ёсны хүрээнд багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр бүтээхэд *-Уур (хадуур)* дагавар голлох үүрэгтэй байсан бол мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо зэрэгт “*төхөөрөмж*” (*хадах төхөөрөмж*), “*машин*” (*хаддаг машин – жатвенная машина*) хэмээх үг түүний үүргийг гүйцэтгэдэг болж байна. Үүнийг Л.Бауер (2023: 6) “моодноос гарах” гэж нэрлэжээ.

2.3. Дагаврын хувилбарын хэрэглээ нэмэгдэх нь. Дагаврын хувилбарын нэгнийх нь хэрэглээ нэмэгдвэл нөгөөх нь мөхөж болно. Монгол хэлэнд олон тооны утга бүхий *-д, -с, -ууд, нар (бид, уулс, сандлууд, багш нар)* гэх мэт олон дагавар байдаг бөгөөд эдгээр нь нэг дагаврын хувилбарууд юм. Гэвч *-д, -с* дагаврын хэрэглээ багасаж, *-ууд, нар* хувилбарынх нь хэрэглээ, давтамж нэмэгдсээр байна. *-д* дагавар *ард (ганц тоо: *аран), хүүхэд (ганц тоо: хүүхэн), бусад (ганц тоо. *бус)* зэрэг үгэнд олны утгаа алдаж, язгууртаа шингэсэн байна. Мөн *охид* (ганц тоо. *охин*), *бид* (ганц тоо. *би*) зэрэг олон тоот хэлбэрт дахин олон тооны *-ууд, нар (охидууд, бид нар)* дагаврыг залгах болжээ. Тиймээс *-д* дагаврыг мөхөж буй дагавар гэж тодорхойлох болжээ. Монгол хэлэнд олон тооны **-н, *-л* дагавар байсан (Рорре, 1987: 175) ба тухайн дагаврууд *-тАн (араатан, жигүүртэн), -чУУл (баячуул, хөгшчүүл)* зэрэг нийлмэл дагаврын бүтцэд хадгалагдан үлдсэн байна. Түүнчлэн үйлдэгдэх хэвийн *-гд* дагаврын хэрэглээ нэмэгдсэнээр *-т/-д* хувилбар нь хэрэглээгүй болж байна. Үгийн бүтцэд уг дагаврын тохиолдох байранд болон ард нь *-гд* орох болжээ. Жишээ нь: *сонст- ~ сонсогд-, авт- ~ автагд-* гэх мэт.

Дагавар мөхөхөд нөлөөлдөг нэг хүчин зүйл бол “тухайн дагаварт өөр өрсөлдөгч байна уу?” гэдэг асуулт юм. Хоёр дагаврын утга, үүрэг ойролцоо юм уу, адилхан байвал ихэнхдээ нэг нь мөхдөг. Цөөн тохиолдолд утгаар (баймж)-аа ялгарна. Бид өмнө нь нэрээс тэмдэг нэр бүтээх *-т, -лАг* дагавар болон харьцангуй хожуу үүссэн *-рхУУ, -рхАг* дагаврын байр, утга, хэрэглээний талаар өгүүлсэн билээ (Ганбаатар, 2017: 43, 2023: 30-31). *-т, -лАг* дагавар анх үүсгэгч үндсийн утгаар илэрч буй юм, үзэгдлийг “агуулах” утга бүхий тэмдэг нэр бүтээдэг байсан бол орчин цагийн монгол хэлэнд *-т* нь үүсгэгч үндсийн утгаар илэрч буй юм, үзэгдлийг “бүрэн агуулсан”, *-лАг* нь “заримдаг агуулсан” болон “адил төстэй” болохыг илтгэдэг утгын бүрэлдэхүүнээрээ ялгарчээ. Түүнчлэн харьцангуй хожуу

үүссэн *-рхАг* (усархаг: ус ихтэй), *-рхУУ* (усархуу: устай төстэй) дагавар *-т* (модот: мод ихтэй), *-лАг* (модлог: 1. мод ихтэй, 2. модтой төстэй) дагавартай адилхан утга илтгэх болж, дээрх дагавруудын хооронд үг бүтээх өрсөлдөөн эрчимжих төлөвтэй байна. Ийм үзэгдэл монгол хэлэнд нийтлэг юм. Тухайлбал, үйлээс нэр үг бүтээх *-УУр* (хөргүүр) дагавраас *-гч* (хөргөгч) дагаврын, тэмдэг нэр бүтээх *-втАр* (боровтор) дагавраас *-дУУ* (бордуу) дагаврын хэрэглээ давтамж нэмэгдсээр байна. *-гч*, *-дУУ* нь саяхан үүссэн дагавар учраас ойролцоо утгатай *-УУр*, *-втАр* дагаврыг хэрэглээнээс шахаж, зарим талаар утгын ялгамжтай болж байна. Дагаврын хувилбарын хэрэглээ нэмэгдэх, үг бүтээх өрсөлдөгч бий болох зэрэг нь дагавар мөхөхөд нөлөөлдөг томоохон хүчин зүйл болно. Монгол хэлэнд шинэ үг бүтээхээ больж мөхсөн, бас мөхөж байгаа дагавар олон байна.

Л.Бауерын тодорхойлсон “дагавар залгах боломжтой үндэс дуусах”, “үндсийн бүтэц тодорхойгүй болох”, “үндэс нь танигдахааргүй болох” зэрэг шалтгааныг язгуурын бүтцэд шингэж мөхсөн дагаврын жишээгээр тайлбарлаж болно.

3. Язгуурын бүтцэд шингэж мөхсөн дагавар. Хэлний түүхэн хувьслын явцад язгуур, дагавар хоёр нэгдэж нэгэн бүтээвэр болсноор язгуур, үндсийн бүтэц тодорхойгүй болж, улмаар дагавар нь мөхдөг. Энэ нь нэр үг, үйл үг, тэмдэг нэр, тооны нэр, орон цагийн нэр гэх мэт бүх үгийн аймгийн үгэнд хамаарна. Үүнээс тооны нэр бүтээх зарим дагаврын талаар товч өгүүлье. Тооны нэр бүтээх дагаврын дотор хэрэглээгүй болж мөхсөн дагавар олон байна. Нэгээс арав хүртэлх үндсэн тооны нэрийн бүтэц нь цуваа цагийн үүднээс анхдагч язгуурт үг бүтээх дагавар залгаж үүссэн нь тодорхой боловч хам цагийн үүднээс язгуур, дагавар гэж задлах боломжгүй болжээ. Жишээ нь: *нэгдэл* хэмээх үгийн язгуур нь *нэг* болно. Тухайн язгуур нь түүхэн үүднээс **ni-+*-ge* гэж хоёр бүтээвэр болж задрах боловч язгуур, дагаврын аль алиных нь утгыг тодорхойлох, таамаглах боломжгүй болжээ. Тиймээс **-ge* -ийг мөхсөн дагавар гэж үзнэ. **ni-* нь *анхдагч язгуур* буюу *мөхсөн язгуур*, харин *nige* нь *үүсмэл язгуур* болно. Анхдагч язгуурт нэг болон хэд хэдэн мөхсөн дагавар залгаж орчин цагийн монгол хэлний үүсмэл язгуурыг бүтээдэг байна.

Орчин цагийн монгол хэлний амьд язгуурын ихэнх нь “анхдагч язгуур + мөхсөн дагавар” гэсэн бүтэцтэй байна. Ц.Өнөрбаян *γuna* ‘гурван настай эр амьтан’, *döne* ‘дөрвөн настай эр амьтан’ зэрэг үгийн бүтэц дэх *-na/-ne* дагаврыг “чөлөөт бус язгуураас нэр үг бүтээх дагавар” (2004: 41) гэж тодорхойлжээ. Хэрэв тийм бол *γu-*, *dö-* нь чөлөөт бус язгуур болох бөгөөд түүний ард байрлах *-ci* (*γuci*, *döci*), *-r* (**γur*, **dör*) дагаврыг ч чөлөөт бус язгуураас үг бүтээдэг дагавар гэж үзнэ. Гэвч орчин цагийн монгол хэлэнд *γu-*, *dö-* язгуур болоод **γur*, **dör* хэлбэрийн утга нь тодорхой танигдахгүй болжээ. Харин түүнд *-ba/-be* дагавар залгавал *γurba*, *dörbe* болж утга нь сая мэдэгдэнэ. Тиймээс *γuna*, *döne* гэсэн хоёрхон үгийн бүтцэд тохиолддог *-na/-ne* дагаврыг мөхсөн дагавар гэж үзэх нь зүйтэй юм.

γuci, *döci* хэмээх дэс тооны нэр болон *γici* ‘хоёрдугаарт’, *qoci* (нэр) ‘хоёр дахь нэр’ зэрэг үгийн бүтцэд *-ci* дагавар тохиолдоно. Тооны нэрийн **ji-*, **γu-*, **dö-* зэрэг анхдагч язгуурт *-ci* дагавар залгаж *γici*, *γuci*, *döci* зэрэг үг бүтжээ. *-ci* дагавар бүхий тооны нэр *γici* ‘өөрийн төрлийн хоёр дахь үе’, *γuci* ‘өөрийн төрлийн гурав дахь үе’, *döci* ‘өөрийн төрлийн дөрөв дэх үе’, *taici* ‘өөрийн төрлийн тав дахь үе’

гэх мэт үгэнд нэршиж, хүний үе удмыг заасан нэр үг болсон аж. Түүнчлэн тухайн дагавар бүхий үгэнд *ači* ‘хүүгийн хүүхэд’ хамаарах бөгөөд **a*- язгуурыг Л.Болд анх “хамгийн түрүүч” (2005: 71) хэмээх үгийн язгуур гэж үзжээ. Монгол хүн өөрөөс доош хоёр дахь үе буюу хүүгийн хүүхдээс (*ач* = нэг) үе удмаа тоолж эхэлдэг байна. *-či* дагавар хүний үе удмыг заасан үгийн бүтцэд хойшоо *-nčir* (*ačincir, jičincir* гэх мэт) дагавартай харьцана.

-či дагавар монгол хэлэнд дэс тооны нэр бүтээдэг байсан (*жич хүү – хоёр дахь үеийн хүү*) боловч хэрэглээгүй болж дээрх үгсийн бүтцэд царцжээ. Тус дагаврын утгыг орчин цагийн монгол хэлэнд *дугаар* (*duyar*), *дахь* (*daki*) дагавар илрүүлж байна. Тиймээс Д.Синор (D.Sinor) зэрэг судлаач *duyar* дагаврыг түрэг хэлний **-ti* дагавар (1959: 422)-тай холбон судалжээ. Алтай язгуурын хэлний **-ti* дагавар нь *дугаар* -аас илүү *-či* (<**-ti*) дагавартай гарлаараа холбогдоно. Дундад үеийн монгол хэлний толь бичигт буй “*tabunci, doluganci*” (Porre, 1938: 68) зэрэг жишээнээс уг дагаврыг *duyar, daki* -ийн нэгэн адил бүх тооны нэрийн үндсэнд залгаж дэс тооны нэр бүтээдэг байсан байх гэж таамаглаж болохоор байна. *Анхдагч* (~ *тоо*), *хоёрдогч* (~ *түүхий эд*), *гуравдагч* (~ *хөрш*) зэргийн бүтэц дэх *-дагч* (*-daci*) хэлбэрийг дэс тооны *-daki* дагаврын ард мөн утга бүхий *-či* дагавар дахин орж бүтсэн нийлмэл хэлбэр гэж үзэж байна. *-дагч* хэлбэрийн бүтэц, гарлын талаар ямар нэг судалгаа, санал байхгүй бөгөөд “*-d (adj/N-V) + -гч (V-N)*” гэсэн бүтэцтэй гэж үзвэл “зохисгүйдэх утга бүхий” *-d* дагаврын ард *-гч* дагавар үл тохиолдох байртай” (Ганбаатар, 2023: 43) байна. Үгийн бүтцэд “*х*”, “*ч*” гийгүүлэгч дараалан орвол “*х*” нь “*г*” болж ондоошдог зүй тогтол бий. Мөхсөн дагавар хааяа “амилж” дахин хэрэглэгдэх тохиолдол байх бөгөөд үүнийг хэл судлаачид хошигнон “ороолон”-той зүйрлэдэг билээ.

Зарим судлаач *γu-*, *γur-* болон *dö-*, *dör-* -ийг язгуурын хувилбарууд (Мөнх-Амгалан, 2014: 118-119) гэж үздэг. *-r* дагавар **γur-*, **dör-* -өөс гадна *jir* -ийн бүтцэд бас тохиолдоно. Ц.Шагдарсүрэн *-r* нь үг үүсгэх нэгэн зүйл дагавар бөгөөд монгол хэлнээ *jir, qoyar, ikere* гэх зэргээр идэвхтэй хэрэглэгддэг (2004: 39-40) гэсэн санал дэвшүүлсэн байна. Д.Төмөртоогоо “**jī-, *γu-, *dö-, *yi-* зэрэг үндсэн тооны үгийн язгуур дээр *-r* дагавар залгаж тухайн тооны үгийн утгыг хадгалсан *jir-, γur-, dör-, yir-* гэсэн үүсмэл язгуурууд бүтжээ” (2011: 137) гэсэн нь *-r* дагаврыг мөхсөн дагавар гэж үзэж буй бидний саналтай нийлж байна.

-r дагаврыг мөхсөн дагавар гэж үзэх өөр нэг баримт бол бусад дагавартай харьцах байр нь юм. Тус дагавар *jirmüsün, γurmusun, dörmüsün* зэрэг үгийн бүтцэд *-musun/-müsün* дагавартай харьцаж байна. *-musun/-müsün* дагавар нь орчин цагийн монгол хэлэнд шинэ үг бүтээхгүй бөгөөд *нэгмөсөн, бүрмөсөн, хоймсон, жирэмсэн, гурамсан, дөрөмсөн* зэрэг нэгээс дөрөв хүртэлх тооны нэрийн бүтцэд тохиолдоно. Тус дагаврын талаар О.Самбуудорж (1992: 76-78) тусгайлан өгүүлэл бичжээ.

Нэгмөсөн, хоймсон хэмээх үгийн *nige, qoyi- / qoya-* язгуурын бүтцэд *-γa/-ge* дагавар байх бөгөөд монгол хэлэнд “*γ/g*” гийгүүлэгч суларч “*y*” болдог ёс бий. Эртний монгол хэлний шүргэх “*γ/g*” гийгүүлэгч суларч дундад үеийн монгол хэлэнд тагнайн шүргэх “*y*” гийгүүлэгч болжээ. Жишээ нь: АМ **sayin* > ММ *sayin*, АМ **tegimü* > ММ *teyimü*, АМ **ačiyān* > ММ *ačiyān*, АМ **tariyācin* > ММ *tariyācin* гэх мэт. Улмаар *saīn, teīm* > *tīm* болж бүрмөсөн сугарсан байна. Энэхүү авианы хувьслыг томъёолбол *γ/g > y > ø* болно.

Монгол бичгийн хэлэнд “нэг”, “хоёр” хэмээх үгийн анхдагч язгуурт *-ya/-yi* дагавар залгах (*ne-yi-*, *qo-ya-* / *qo-yi-*) бөгөөд түүнээс *ne-yi-te*, *ne-yi-gem*; *qo-ya-r*, *qo-ya-yul*, *qo-yi-musun* зэрэг үг үүсжээ. Түүнчлэн *qo-ya-* үндсээс *qoyina*, *qoyitu* зэрэг үг бүтнэ.

-ya/-ge дагавар *nijeged* ‘*тус бүрд нэг*’ хэмээх түгээл тооны нэрийн бүтцэд *-je* хэлбэрээр тохиолдоно. Энэ нь бүтээврийн авиалбар зүйн үзэгдлийн нөлөөгөөр “*γ*” гийгүүлэгч “*ǰ*” (*nijeged* < **negeged*) болон ондоошсон авианы нөлөөтөн хувьсах үзэгдэл болно. Энэхүү авианы хувьсал монгол хэл, аялгуунуудад бас ажиглагдана. Буриад аялгуунд *anjjar* (*anjir* < *angir*) ‘*ангир*’, *erje* (< *ergi*) ‘*эрэг*’ гэх мэтээр “*i*”-гийн өмнө орсон “*g*” нь арынхаа эгшгийн нөлөөгөөр тагнайшиж “*j*” болсон байна. Зарим аялгуунд *nijeged* биш *nijeyed* хэлбэрээр тохиолдоно. *-ya/-ge* дагаврыг олонх судлаач *-yan/-gen* хэлбэртэй гэж үзсэн байдаг ч утгаа *-n* нь үндэс үүсгэх үүрэгтэй бүтээвэр юм.

Д.Төмөртогоо *-yan*, *-ban*, *-man* -ыг дагаврын хувилбар гэж үзээд “**ni-*, **γur-*, **dör-*, **ǰir-γu-*, **dal-*, **nay-*, **min-* гэсэн тооны үгийн язгуур дээр *-yan/-gen* ~ *-ban* / *-ben* ~ *-man* / *-men* дагаврын зохих хувилбарыг залгаж, *nigen*, *γurban*, *dörben*, *ǰirγuγa:n*, *doluγa:n*, *nayman*, *miγyan* гэсэн тооны үгийн үндэс үүсжээ” (2011: 137) гэжээ. Анх Г.Й.Рамстедт (G.Ramstedt) (1907: 8) *-ban* / *-ben* дагаврыг *-man* (*nayman* ‘*eight*’)-тай холбож тайлбарласан байна. Бид дээрх саналыг дэмжиж байна. Учир нь монгол хэлний зарим залгавар бүтээвэр түүхэн хувьслын явцад болон бүтээврийн авиалбар зүйн үзэгдлийн нөлөөгөөр “*γ/g*”, “*b*”, “*m*” гийгүүлэгч бүхий хувилбартай болох нь түгээмэл байдаг. Тухайлбал, үйлээс нэр үг бүтээх *-buri* / *büri* дагавар *-muri* / *müri*, *-γuri* / *güri* гэсэн хувилбараар илэрнэ. *-ba* / *-be* дагавар *γurban*, *dörben* зэрэг үгийн бүтцэд *-r* дагаврын ард, *-ma* хувилбар нь *nayman* хэмээх үгэнд тохиолдоно.

Тооны нэр бүтээх *-na* / *-ne*, *-ci*, *-r* болон *-ya* / *-ge* / *-yi* (*-ba* / *-be*, *-ma* / *-me*) дагавар урагшаа анхдагч язгууртай харьцах бөгөөд язгуур дагаврын аль аль нь мөхсөн байна. Тиймээс *γuna*, *ǰici*, **ǰir* (*in*), *nige* зэргийг үүсмэл язгуур гэж үзнэ. Мөн *γu-*, *dө-* язгуурт залгасан *-na* / *-ne* (*γuna*, *dөne*) дагавраас гадна *-ǰi* (*γunǰi* ‘*гурван настай эм бод мал*’, *dөǰi* ‘*дөрвөн настай эм бод мал*’) дагавар ч бас орчин цагийн монгол хэлэнд шинэ үг бүтээхээ больжээ. *-ǰi* дагаврыг судлаачид (Өнөрбаян, 2004: 36; Мөнх-Амгалан, 2014: 30) чөлөөт язгуураас үг бүтээх дагавар буюу амьд дагавар гэж тодорхойлоод *нэгж*, *дундаж*, *урвалж* зэрэг жишээ татсан байна. Өмнөх жишээнд буй дагаврыг эм хүйс заадаг *-ǰi* дагавар биш, ижил дагавар (homosuffix)-ууд гэж үзэж байна. Тухайлбал, *дундаж* хэмээх үгийн *-ǰi* дагаврыг тооны нэр бүтээх дагавар гэхээс илүү *дээж*, *доож*, *дотоож* зэрэг үгийн бүтэц дэх орны нэр бүтээх *-ж* (*-d*) дагавар гэж үзвэл зохино. Нөгөө талаар *-ǰi* дагавар эм хүйс заахдаа зөвхөн *γunǰi*, *dөǰi* хоёрын бүтцэд л орж байна. Нэмэн тэмдэглэхэд тус дагаврыг *γuna* ‘*гурван настай эр амьтан*’, *dөne* ‘*дөрвөн настай эр амьтан*’ хэмээх үндсэнд залгасан гэж үздэг боловч хэлний баримтад эр хүйс заах утгатай бүтээврийн ард эм хүйс заадаг бүтээвэр орж, эм хүйсийн утга илтгэсэн тохиолдол таарсангүй. Өөрөөр хэлбэл, *цагаадай* (эр хүйс) - *цагаагчин* (эм хүйс), *монголдой* (эр хүйс) - *монголжин* (эм хүйс), *гэрэлт* (*gereltü kö'ün* / эр хүйс) - *гэрэлтэй* (*gereltei ökin* / эм хүйс) гэх мэтээр парадигм харьцаа үүсгэдэг аж. Тиймээс *γu* + *-ǰi* бүтэцтэй буюу *-(n)ǰi* дагавар гэж үзэх саналтай байна.

Орчин цагийн монгол хэлний үүднээс *γurba, dörbe* хэмээх үгийн бүтэц дэх *-r, -ba* дагавар мөхсөн учраас *γurba, dörbe* -ийг идэвхтэй язгуур (free root) гэж үзэж байна. *qoyar, γurba* зэрэг үгийн бүтэц дэх *-γa/-ge (-ya/-yi), -r, -ba/-be* дагаврыг мөхсөн дагавар гэж үзэж байгаа нь Ш.Лувсанванданы “мөхсөн анхдагч язгуур дээр мөн мөхсөн нэг буюу (болон Ж.Г) хэд хэдэн дагавар залгаж” (1963/2010: 76) үүсмэл язгуур бүтнэ гэсэн саналтай нийлж байна.

Тооны нэрийн бүтэц болоод тооны нэр бүтээх дагаврын талаарх судалгаа нэлээд байдаг учраас бид нэгээс арав хүртэлх тооны нэрийн бүтцэд нийтлэг тохиолддог цөөн дагавар болон тооны нэрийн анхдагч язгуурын талаар өгүүллээ.

4. Хэлэлцүүлэг. Үгийн гарлыг судлан тогтооход чөлөөт болоод чөлөөт бус язгуурыг түүхэн үүднээс задлан тайлбарлах нь чухал юм. Гэвч монгол хэл шинжлэлд язгуурын бүтцийг цааш нь задлан тайлбарлаж, анхдагч язгуурыг тогтоосон судалгаа бараг байхгүй байна. Тухайн үгийн анхдагч язгуурыг тогтооход мөхсөн дагаврын тухай асуудал зайлшгүй урган гардаг. Түүнчлэн язгуурын бүтцэд шингэж мөхсөн дагавар тооны нэрийн язгуураас гадна нэр үг, үйл үг, тэмдэг нэр, орон цагийн нэр, завсрын үг (дүрслэх болон дуурайх) гэх мэт бүх үгийн аймгийн үгэнд хамаарна. Тиймээс монгол хэлний мөхсөн дагаврыг бүхэлд нь тусгайлан судлах шаардлага урган гарч байна. Түүнчлэн зарим мөхсөн дагавар “амилж” дахин хэрэглээнд орох цөөн тохиолдол байх бөгөөд бид *-дагч* хэлбэрийн талаар дурдсан билээ. Мөхсөн дагавар “амилах” шалтгаан болон тэдгээр дагаврын талаар судалбал сонирхолтой байна.

Дүгнэлт

Орчин цагийн монгол хэлэнд шинэ үг бүтээх болон үг хувилгах ёсонд нийлэг аргаас илүү задлаг арга бүтээлч болж байна. Тиймээс зарим дагаврын хэрэглээ багасаж, задлаг хэлбэртээ түрэгдэх хандлагатай байна. Үг бүтэх ёсны хүрээнд дагаврын аргаар үг бүтэхээс илүү үг нийлэх арга нь бүтээлч болжээ. Үүнээс шалтгаалж монгол хэлэнд бүтээлч биш дагавар болон мөхсөн дагавар олшрох төлөвтэй байна. Бид цөөн үгийн бүтцэд тохиолддог, шинэ үг бүтээдэггүй, утга нь тодорхой мэдэгдэхээ больсон зарим дагавар (*-мсАр* мэт)-ыг мөхсөн дагавар гэж үзлээ. Түүнчлэн чөлөөт болон чөлөөт бус язгуурын бүтцэд царцсан дагавар олон байх бөгөөд тус өгүүлэлд зөвхөн чөлөөт язгуурын бүтэц дэх мөхсөн дагаврын талаар авч үзлээ. *Нэг, хоёр, жич, гуч* зэрэг нь түүхэн үүднээс анхдагч язгуур, мөхсөн дагавар гэсэн бүтэцтэй боловч орчин цагийн монгол хэлний үүднээс чөлөөт язгуур болно. Энэ нь Ш.Лувсанванданы тодорхойлсон мөхсөн анхдагч язгуур дээр нэг болон хэд хэдэн мөхсөн дагавар залгаж, үүсмэл язгуур бүтээнэ гэсэн саналтай нийлж байна.

Ном зүй

Болд, Л. (2005). *Түрэг, монгол хэлний тооны нэр*. Улаанбаатар.

Ганбаатар, Ж. (2017). Нэрээс тэмдэг нэр бүтээх дагаврын байрлалын тогтолцоо. *Хэл зохиол судлал*, 10(42), 37-50.

Ганбаатар, Ж. (2023). *Монгол хэлний дагавар: байр, үүрэг, хэрэглээ*. Улаанбаатар.

Лувсанвандан, Ш. (1963). Монгол хэлний үгийн зарим язгуур, үндсийн тухай. *МУИС, Эрдэм шинжилгээний сонсгол*, 1, 3-4; (2010). *Шадавын Лувсанвандан бүтээлийн чуулган, VII боть*, 76-77.

- Лувсанвандан, Ш. (1964). Монгол хэлний үгийн бүтцийн тухай асуудалд. *МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг*, 8, 3-16; (2019) Ш.Лувсанвандан. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган V*, (Монгол хэлний бүтээвэр, өгүүлбэр, үгийн сан судлал). Улаанбаатар.
- Лувсанвандан, Ш. (1968). *Орчин цагийн монгол хэлний бүтэц (дэд дэвтэр)*. Улаанбаатар: ШУАХ.
- Мөнх-Амгалан, Ю., Кан Шин. (2014). *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал*. Улаанбаатар.
- Өнөрбаян, Ц. (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.
- Поппе, Н.Н. (1927). Монгольские числительные. *Языковедческие проблемы по числительности*, 97-119.
- Поппе, Н.Н. (1938). *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб*. Москва.
- Ринчен, Б. (1966). *Монгол бичгийн хэлний зүй (Хэлбэр судлал)*. Улаанбаатар.
- Самбуудорж, О. (1992). Монгол хэлний -musun, түсүн дагавартай хэдэн үгийн болон дагаврын утга, гарлын тухайд. *Шинжлэх Ухааны Академийн мэдээ*, 1, 76-78.
- Төмөртоого, Д. (2011). *Монгол хэлний бичгийн дурсгалуудын үгийн бүтцийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар.
- Шагдарсүрэн, Ц. (2004). Монгол хэлний “qoyar / jirin” гэдэг тооны нэрийг мөшгөсөн нь. *Acta Mongolica*, 3(215), 33-52.
- Bauer, L. (2023). The Birth and Death of Affixes and Other Morphological Processes in English Derivation. *Languages*, 8(4), 244.
- Hashimoto, M. (1985). Some Remarks on the Language of the Secret History of the Mongols with Reference to the Deverbal Suffixes -muser, -msar. *Олон улсын монголч эрдэмтний их хурал*, 4(2), 421-426.
- Lewicki, M. (1949). Turkica et Mongolica. *Rocznik Orientalistyczny*, 15, 239-267.
- Poppe, N. (1987). *Introduction to Mongolian Comparative Studies*. Helsinki.
- Ramstedt, G.J. (1907). Über die Zahlwörter der altaischen Sprachen. *Journal de la Société Finno-Ougrienne / Suomalais-Ugrilaisen Seuran Aikakauskirja* 24.1, 1-24.
- Sinor, D. (1959). *A Ural-Altai ordinal suffix. Ural-Altaiische Jahrbücher: Fortsetzung der “Ungarischen Jahrbücher”*, 417-425.

Abstract

The examination of changes within inflectional systems and the origin and extinction of inflectional morphemes holds significant importance in understanding language evolution. Throughout linguistic development and its evolution, new morphemes emerge while others fall into disuse. Despite the prevalence of frozen and extinct suffixes within Mongolian root structures, there exists a notable gap in research concerning these extinct morphemes. This paper addresses the frozen suffixes within free root structures, focusing specifically on numerals as exemplars.

We propose identifying certain suffixes, occurring in limited number of word structures, and failing to form new words, as extinct suffixes. Specifically, we identify *-na/-ne*, *-či*, *-r*, *-ya/-ge* (*-ba/-be*, *-ma/-me*), and *-ji* suffixes within numeral constructions as examples of extinct morphemes. These suffixes are embedded within the structure of free roots in contemporary Mongolian, aligning with Sh.Luvsanvandan’s assertion that “one or more extinct suffixes are affixed to extinct primary roots” (1963) to create derived roots.

In contrast to suffixation, compounding shows greater creativity in word formation. Consequently, non-productive, and extinct suffixes tend to increase in the Mongolian language over time.